

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/84/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Мөрөн 2022 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 70383793 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ Утас: 99900662 Цахим хаяг: bat-erdenee@audit.gov.mn Ахлах аудитор: Утас: Л.Отгонбаяр Цахим хаяг: imfo@bizkon.mn Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 99996784 Цахим хаяг: mm.bayar0711@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХӨА	Хөвсгөл аймаг
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.21 № 01/99
танай -ны № -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>135,616,666.56</u>	<u>132,295,062.92</u>
33	АВЛАГА	5,026,700.00	25,293.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	25,293.00
335	Бусад авлага	5,026,700.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	5,026,700.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	130,589,966.56	132,269,769.92
351	Түүхий эд материал	5,499,000.00	1,281,200.00
35130	Эм боох материал	5,499,000.00	1,281,200.00
354	Хангамжийн материал	123,693,966.56	129,874,569.92
35410	Бичиг хэргийн материал	4,362,510.00	2,355,000.00
35420	Аж ахуйн материал	36,603,404.28	45,813,154.02
35440	Түлш, шатах тослох материал	4,700,530.00	5,199,000.00
35460	Хүнсний материал	7,604,677.00	5,713,510.00
35470	Бусад хангамжийн материал	70,422,845.28	70,793,905.90
35600	Мал амьтад	1,397,000.00	1,114,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,397,447,636.74</u>	<u>4,355,049,717.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,397,447,636.74	4,355,049,717.56
392	Биет хөрөнгө	4,312,133,636.74	4,268,580,717.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,087,069,763.64	4,087,069,763.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-173,422,950.90	-290,384,617.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	256,027,423.20	194,028,418.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-189,627,889.71	-34,282,378.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	158,369,259.22	163,518,435.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,902,838.67	-64,522,973.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	266,933,341.86	264,551,803.25
39215	Хуримтлагдсан элэгдэл	-57,688,393.44	-81,757,833.15
39217	Ном	36,375,921.54	30,360,100.16
393	Биет бус хөрөнгө	85,314,000.00	86,469,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	86,101,000.00	86,469,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-787,000.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,533,064,303.30</u>	<u>4,487,344,780.48</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,533,064,303.30</u>	<u>4,487,344,780.48</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,533,064,303.30	4,487,344,780.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	976,754,083.81	976,754,083.81
51101	Өмч: - төрийн	976,754,083.81	976,754,083.81
512	Хуримтлагдсан үр дүн	1,961,953,430.70	1,921,894,029.88
51210	Өмнөх үеийн үр дүн	1,961,953,430.70	1,967,613,552.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-45,719,522.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,594,356,788.79	1,588,696,666.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,533,064,303.30</u>	<u>4,487,344,780.48</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,249,254,117.00	2,005,223,055.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,343,028,217.00	148,768,312.86
120	Нийтлэг татварын бус орлого	2,343,028,217.00	148,768,312.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,339,359,017.00	145,710,912.86
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,357,500.00	1,244,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	358,900.00	342,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,337,642,617.00	144,124,412.86
120009	Бусад орлого	3,669,200.00	3,057,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,233,300.00	482,659,242.91
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,430,992,600.00	1,373,795,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	9,289,842.91
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,289,842.91
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	475,233,300.00	473,369,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	475,233,300.00	473,369,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,984,875,820.04	2,039,599,707.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,984,875,820.04	2,039,599,707.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,890,827,286.04	1,999,975,817.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,055,781,690.00	1,081,955,113.00
210101	Үндсэн цалин	1,055,781,690.00	913,483,562.00
210102	Нэмэгдэл	00.00	121,032,403.00
210104	Урамшуулал	00.00	47,439,148.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,600,019.00	142,703,504.00
210201	Тэтгэврийн даатгал	91,277,681.00	100,622,949.97
210202	Тэтгэмжийн даатгал	10,555,633.00	10,819,951.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,444,506.00	8,655,960.27
210204	Ажилгүйдлийн даатгал	2,029,290.00	2,054,967.73
210205	Эрүүл мэндийн даатгал	20,292,909.00	20,549,675.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	463,042,100.00	466,141,500.00
210301	Гэрэл, цахилгаан	13,000,000.00	8,000,000.00
210302	Түлш, халаалт	447,042,100.00	458,141,500.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,848,670.00	41,969,691.17
210401	Бичиг хэрэг	9,795,090.00	6,850,540.91
210402	Тээвэр, шатахуун	4,729,670.00	3,729,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	820,200.00	745,200.00
210404	Ном, хэвлэл	64,000.00	6,546,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,155,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,284,710.00	10,814,300.00

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210408	Бараа материал акталсны зардал	00.00	13,283,820.26
2105	Нормативт зардал	43,756,660.00	67,732,129.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,214,600.00	6,836,212.00
210502	Хоол, хүнс	39,542,060.00	60,895,917.00
2107	Томилолт, зочны зардал	156,000.00	590,000.00
210702	Дотоод албан томилолт	156,000.00	590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,023,700.00	2,649,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	523,700.00	1,641,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,618,447.04	196,234,080.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	410,000.00	2,731,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	167,208,447.04	193,502,280.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,048,534.00	39,623,890.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,367,900.00	36,401,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,816,800.00	35,407,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,551,100.00	994,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,680,634.00	3,222,090.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,680,634.00	3,222,090.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	2,264,378,296.96	-34,376,651.52
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	11,342,871.30
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	11,342,871.30
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	00.00	-11,342,871.30
5	НИЙТ ҮР ДҮН	2,264,378,296.96	-45,719,522.82

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	976,754,083.81	1,594,356,788.79	-302,424,866.26	2,268,686,006.34
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	976,754,083.81	1,594,356,788.79	-302,424,866.26	2,268,686,006.34
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,264,378,296.96	2,264,378,296.96
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	976,754,083.81	1,594,356,788.79	1,961,953,430.70	4,533,064,303.30
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	976,754,083.81	1,594,356,788.79	1,961,953,430.70	4,533,064,303.30
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,660,122.00	5,660,122.00

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	976,754,083.81	1,594,356,788.79	1,967,613,552.70	4,538,724,425.30
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт, бууралт	00.00	-5,660,122.00	00.00	-5,660,122.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-45,719,522.82	-45,719,522.82
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	976,754,083.81	1,588,696,666.79	1,921,894,029.88	4,487,344,780.48

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,911,252,600.00	1,865,782,842.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,026,700.00	9,328,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,026,700.00	9,328,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,357,500.00	1,244,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,357,500.00	1,244,000.00
120009	Бусад орлого	3,669,200.00	8,084,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,906,225,900.00	1,856,454,742.91
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,430,992,600.00	1,373,795,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	9,289,842.91
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,289,842.91
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	475,233,300.00	473,369,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	475,233,300.00	473,369,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,864,362,480.00	1,836,639,342.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,864,362,480.00	1,836,639,342.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,765,651,026.00	1,797,709,452.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,055,814,191.00	1,081,615,908.00
210101	Үндсэн цалин	907,127,191.00	744,264,755.00
210102	Нэмэгдэл	65,734,400.00	271,435,294.00
210104	Урамшуулал	77,912,600.00	65,915,859.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,567,518.00	143,068,002.00
210201	Тэтгэврийн даатгал	96,173,618.00	101,951,202.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,098,300.00	10,279,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,279,100.00	8,223,200.00

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	1,820,000.00	2,056,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,196,500.00	20,558,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	463,641,500.00	466,641,500.00
210301	Гэрэл, цахилгаан	13,000,000.00	8,000,000.00
210302	Түлш, халаалт	447,641,500.00	458,641,500.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,067,210.00	20,636,612.91
210401	Бичиг хэрэг	971,700.00	1,251,800.91
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	820,200.00	745,200.00
210404	Ном, хэвлэл	64,000.00	6,546,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,336,200.00	1,290,912.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,875,110.00	7,302,700.00
2105	Нормативт зардал	66,704,757.00	59,740,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,330,400.00	927,500.00
210502	Хоол, хүнс	39,535,957.00	56,673,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,838,400.00	2,139,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,362,000.00	16,035,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,505,000.00	9,278,000.00
210602	Тавилга	7,457,000.00	30,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	6,727,900.00
2107	Томилолт, зочны зардал	156,000.00	590,000.00
210702	Дотоод албан томилолт	156,000.00	590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,023,700.00	2,829,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	523,700.00	1,821,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,314,150.00	6,551,330.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,314,150.00	6,551,330.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,711,454.00	38,929,890.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,004,120.00	35,707,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,178,620.00	35,407,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	825,500.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	77,707,334.00	3,222,090.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	77,707,334.00	3,222,090.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	46,890,120.00	29,143,500.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	46,890,120.00	29,143,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,890,120.00	29,143,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	46,890,120.00	29,143,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,890,120.00	29,143,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-46,890,120.00	-29,143,500.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,847,164,900.00	1,843,942,810.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,847,164,900.00	1,843,942,810.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,811,590,000.00	1,808,535,010.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,081,655,800.00	1,081,615,908.00
210101	Үндсэн цалин	773,854,100.00	744,264,755.00
210102	Нэмэгдэл	248,641,700.00	271,435,294.00
210104	Урамшуулал	59,160,000.00	65,915,859.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,023,400.00	143,068,002.00
210201	Тэтгэврийн даатгал	102,757,300.00	101,951,202.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,816,500.00	10,279,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,653,200.00	8,223,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,163,300.00	2,056,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,633,100.00	20,558,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	466,641,500.00	466,641,500.00
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	8,000,000.00
210302	Түлш, халаалт	458,641,500.00	458,641,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,963,100.00	10,950,170.00
210401	Бичиг хэрэг	757,700.00	757,270.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	757,700.00	745,200.00
210404	Ном, хэвлэл	631,500.00	631,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	795,600.00	795,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,520,600.00	4,520,600.00
2105	Нормативт зардал	59,740,400.00	59,740,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	927,500.00	927,500.00
210502	Хоол, хүнс	56,673,600.00	56,673,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,139,300.00	2,139,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,727,900.00	36,727,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	6,727,900.00	6,727,900.00
2107	Томилолт, зочны зардал	636,500.00	590,000.00
210702	Дотоод албан томилолт	636,500.00	590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,649,800.00	2,649,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,641,800.00	1,641,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,551,600.00	6,551,330.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,551,600.00	6,551,330.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,574,900.00	35,407,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,574,900.00	35,407,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,574,900.00	35,407,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,847,164,900.00	1,843,942,810.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,373,795,500.00	1,370,573,410.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,373,795,500.00	1,370,573,410.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	473,369,400.00	473,369,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	473,369,400.00	473,369,400.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,617,942.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,617,942.91
2104	Хангамж, бараа материалын зардал	10,317,942.91
210401	Бичиг хэрэг	494,530.91
210404	Ном, хэвлэл	6,546,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	495,312.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,782,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,617,942.91
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,244,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,244,000.00
140020	БУСАД ЭХ ҮҮСВЭР	8,084,100.00
140020	Бусад орлого	8,084,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,289,842.91
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,289,842.91

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарын ахлах аудитор Л.Отгонбаяр, аудитор Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд “Хосолсон сургалтаар бие даан суралцах чадварыг хөгжүүлж, хоцрогдлыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ” гэсэн зорилго тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ыг хэрэгжүүлэх, “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “9.5” гэснийг “8.5” гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “9.5” гэснийг “8.5” гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “12.7” гэснийг “11.7” гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “12.5” гэснийг “11.5” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “12.5 хувиас” гэснийг “11.5 хувиас” гэж тус тус өөрчилсүгэй” гэж заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Мөн Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн баталсныг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/375 дугаар захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,984.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 39.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 31.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45.7 сая төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материалын данс 1.7 сая төгрөгөөр өсөж, авлага 5.0 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн данс 42.4 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	5.1	0.02	-5.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	130.5	132.2	1.7
Үндсэн хөрөнгө	4,397.4	4,355.0	-42.4
Нийт хөрөнгө	4,533.0	4,487.3	-45.7
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,533.0	4,487.3	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,533.0	4,487.3	-45.7

Тайлант онд мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдэл байхгүй бөгөөд, 0.02 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 1.7 сая төгрөгөөр өсөж 132.2 сая төгрөг болсон нь Боловсролын яамнаас үнэ төлбөргүй 10.8 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, улсын төсвийн хөрөнгөөр 97.4 сая төгрөгийн хоол хүнс, түлш, аж ахуйн материал худалдаж авсан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлт нь ажилчдын барьсан 4.6 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн зам талбай хашаа, төсвийн хөрөнгөөр 29.1 сая төгрөгийн хөрөнгө, улсын төсвөөс 31.5 сая төгрөгийн компьютер, принтер, багшийн ширээ сандал, тоног төхөөрөмж, ЗДТГ-аас 1.6 сая төгрөгийн худгийг тус тус бүртгэсэн байна.

0 үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлж 95.6 сая төгрөгөөр бүртгэсэн бөгөөд нийт хөрөнгө 101.1 сая төгрөгөөр буурсан байна. Мөн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор 30.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 976.8 сая төгрөг байна.

Тус сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 2,247.2 сая төгрөгөөр буюу 47.1 хувиар буурсан байна.

Энэ нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 2,193.5 сая төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 60.4 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс санхүүжих орлого 1.8 сая төгрөгөөр тус тус буурсан, нэмэлт санхүүжилтийн орлого 9.3 сая төгрөгөөр өссөн зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардал 2,036.3 сая төгрөг бөгөөд өмнөх оноос 51.5 сая төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна. Энэ нь цалин, хөлс, болон нэмэгдэл урамшуулал 26.1 сая төгрөг, НДШ-ийн зардал 10.1 сая төгрөг, түлш халаалтын зардал 11.0 сая төгрөг, ном хэвлэлийн зардал 6.4 сая төгрөг, хоолны зардал 21.3 сая төгрөг, үдийн цайны зардал 15.5 сая бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал 1.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Монгол улсын Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35 дугаар тушаалын дагуу “Ур чадварын нэмэгдэл олгох тухай” нэмэгдэл цалин хөлс зардал нэмэгдэж үүнтэй холбоотойгоор НДШ өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 5.7 сая төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн залруулгад бичилт хийсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,906.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,906.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 59.1 сая төгрөгөөр бууруулж 1,847.1 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсөвт 2 удаа зохицуулалт хийсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 1,373.8 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 473.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,373.8 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 473.4 сая төгрөг, нийт 1,847.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,843.9 сая төгрөгийг зарцуулж, 3.2 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,843.9 сая төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Энэ нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 0.04 сая төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2.9 сая төгрөг, шуудан холбоо 0.01 сая төгрөгөөр, дотоод

албан томилолт 0.05 сая төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж дэмжлэг /үдийн цайны зардал/ 0.2 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 9.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.3 сая төгрөг, бусад орлого буюу үндсэн үйл ажиллагааны орлого болох түрээсийн сурах бичгийн төлбөр болон өмнөх оны авлагын орлого 8.1 сая төгрөгийн орлого нийт 18.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 10.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хураамж төлбөрт 8.0 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг /нэг удаагийн тэтгэмж шагналыг урамшуулал/-д 0.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага:

- Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
- Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Аймгийн орон нутгийн төсвөөс Ган өрлөг ХХК нь 1.2 сая төгрөгийн ариутгал халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ хийсэн. Иргэдээс 1.0 сая төгрөг, БШУЯ-аас 0.2 сая төгрөг, Тосон сайхан ХХК -аас 0.8 сая төгрөгийн бараа бараа материал хандиваар хүлээн авсан байна. Хандивын мэдээллийг шилэн дансанд байршуулж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 4 дүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар анхны батлагдсан төсөвт тодотгол хийж 86.9 сая төгрөгөөр, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар 82.7 сая төгрөгөөр төсвийн зохицуулалт хийж нийт 169,6 сая төгрөгөөр төсвийг нэмэгдүүлж баталсан байна. МУ-ын БШУ сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/35 дугаар тушаалын дагуу цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулал, ажил олгогчоос олгох НДШ нэмэгдсэн байна. 2022 онд үдийн хоол хөтөлбөр хэрэгжих болсонтой холбогдуулан багаж, техник хэрэгсэл, тавилга худалдан авсан байна.

Тус сургууль нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 3.0 сая төгрөг, томилолтын зардлаас 0.5 сая төгрөг, хоолны зардлаас 29.9 сая төгрөг, үдийн цай хөтөлбөрөөс 17.2

сая төгрөгөөр тус тус хэмнэж дутуу санхүүжүүлсэн зардалд аймгийн Засаг даргын захирамжаар зохицуулалт хийлгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 2,991.9 сая төгрөгийн /давхардсан тоогоор/ 151 мэдээллээс 2,991.9 сая төгрөгийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна. Хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй нийцсэн байна гэж дүгнэлээ.

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно. Тайлант 648.2 сая төгрөгийн үнэ бүхий 25 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд харьцуулалтын аргаар 22 шууд худалдан авах аргаар 3 арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил, санал гомдол байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар зөвлөмж өгсөн байна. Үүнд: 0 үлдэгдэлтэй хөрөнгийн дахин үнэлгээ хийх, ЗГ-ын 2019 оны 450 дугаар тогтоолд заасны дагуу ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3745 байх заалтыг мөрдөж ажиллах гэсэн зөвлөмжүүдийг тус тус өгснийг хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн хэрэгжилт 100% байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар ямар нэгэн буруу илэрхийлэл, алдаа зөрчил илрээгүй болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

